



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймаг дахь Ангаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/1/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Дорноговь аймаг)

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020

Аудитор:

Утас: 99359854

Цахим хаяг: dornogovi@audit.gov.com

Цахим хаяг:

Б.Байгал

Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
НХМ	Нэг хэвийн маягт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
	Багш ажилчдын орон тоо бүтэц зохион байгуулалт, багшын ажлын ачаалал	9
	Тус сургуулийн тогтмол зардлын төрөөс олгодог санхүүжилтийн он дамжсан өр авлагыг Сангийн яамнаас шийдвэрлэх эсэх асуудал анхаарал татсан асуудалд орж байна	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
3.	Менежментийн захидал	12
3.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа	13
3.2	Зардлын данстай холбоотой асуудал	14
3.3	Удирдлагын дээд болон дотоод хяналт	15
3.4	Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт.....	16
3.5	Балансын данстай холбоотой асуудал	17
3.6	Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	18
3.7	Орлогын данстай холбоотой асуудал	19
3.8	Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин.....	20

1 Аудитын гэрчилгээ


ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд оум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН САЛБАР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.ЦАБШИР ТАНАА

2019-02-23 № 16/118
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

9828837

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Ц.Цабшир-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.17-ноос 2019.02.21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын гэрээт “Мөнгө нөөц баялаг Аудит” ХХК-н хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө нөөц баялаг Аудит” ХХК-д 2019.01.24-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль нь Эрдэм шинжилгээ сургалт, эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг үзүүлдэг бөгөөд олон улсын хэмжээнд манлайлагч их сургуулийн орон нутаг дахь салбар их сургууль байх. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Их дээд сургуулийн үйл ажиллагааг Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Олон улсын хөгжлийн нийтлэг хандлага бүс нутгийн болон үндэсний эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ, сургалт эрүүл мэндийн

тусламж үйлчилгээний нэгдлийг хангасан, мэдлэгт суурилсан, нийгэмд өрсөлдөх чадвартай эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн бэлтгэдэг, орон нутаг дахь Анагаах Ухааны тэргүүлэх салбар сургууль болох.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ЮУНИКОС” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлогын 1* хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төлөвлөлтийн шатанд нийт орлогыг суурь болгож авсныг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль 2018 оны *Нийт орлого* 2,312,680,6 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 23,126,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь орлогын 1 хувиас бага эрсдэл нь санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 15 чиглэлээр аудитын 35 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 14 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна санхүүгийн тайлангийн дансны уялдааг шалгаж зөрүүтэй асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	8	17850.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	8	17850.00	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнгээр гарсан алдаа зөрчлүүдээс материаллаг алдаа зөрчил 17850,0 мянган төгрөг байгаа нь тогтоосон материаллаг байдлын төвшнөөс бага, өгсөн зөвлөмжүүд нь шинж чанарын хувьд тус байгууллагын хэтийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаа, бодлого төлөвлөлтийг сайжруулах бодлогын шинж чанартай 14 зөвлөмж өгөгдсөн болно.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Багш ажилчдын орон тоо бүтэц зохион байгуулалт, багшийн ажлын ачаалал

Тус сургуулийн тогтмол зардлын төрөөс олгодог санхүүжилтийн он дамжсан өр авлагыг Сангийн яамнаас шийдвэрлэх эсэх асуудал анхаарал татсан асуудалд орж байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 15 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,247,113,7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлд, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,596,051,6 мянган төгрөг буюу 71,0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны орлого буюу оюутны элсэлттэй холбоотой орлого буурсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Улаанбаатар хотын АШУИС-ийн нэгдсэн дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлт авсан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжид салбар сургуультай хамаатай зөвлөмж байгаа эсэх талаар албан бичгээр ирүүлээгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан

үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургууль нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Санхүүгийн программд сургалтын болон, номын сангийн үйлчилгээний программыг холбож цогц болгохгүй байгаа нь үндсэн үйл ажиллагааны мэдээ тайланг шуурхай, хяналттай авах, нөхцөлийг хангахгүй байна, НБББББаримтыг Салбар сургуулийн үйл ажиллагааны орлогын онцлог, ашиглаж байгаа сургалтын, санхүүгийн программуудын онцлогийг харгалзан боловсруулж баталж мөрдөөгүй байна, Үндсэн хөрөнгийн ажил гүйлгээг алдаатай бүртгэсэн, хөрөнгийн тооллого, тооцооллыг үнэн зөв хийссэнийг хянах боломжгүй, Үндсэн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийг тооцсон тооцооллын үндэслэл байхгүй байна. Энэ нь НББ тухай хууль 18.2.-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.”заасан заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

Санхүүгийн бүртгэл хөтлөлт стандарт хууль журам зөрчиж алдаатай бүртгэгдэх

Зөвлөмж

Санхүүгийн программд хөгжүүлэлт хийх, НББ бодлогын баримт бичгийг боловсруулах, хөрөнгийн бүртгэл тооллогыг хянаж байх боломжоор хангах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн Захирал Ц.Цабшир нягтлан бодогч Э.Аззаяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 21-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Тайлант жилийн сургалтын цагийн биелэлтээс дүгнэхэд нийт багш нарын илүү цагийн ачаалал АШУИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмын 4.5-р заалтын нормоос 2 дахин илүү байна. Энэ нь багш нар өөрийгөө хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажил хийх боломжийг хязгаарлах эрсдэлтэй. Тайлант жилийн эхэнд тэнхим бүр сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн хэсгүүдээр төлөвлөгөө гаргаж батлуулж, жилийн эцэст багш бүр хийсэн ажлын тайлан бэлтгэн эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны өөрийн үнэлгээг өгдөг хэдий ч багш бүрээр оноог хянаж, баталгаажуулж эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг дүгнэж тайлант жилийн илүү дутуу оноог тооцоолж ажиллаагүй нь багш нарын тайлант хугацааны цалингийн зардал илүү дутуу олгогдох магадлалтай. АШУИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журамд эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх аргачлал тодорхойлогдсон бөгөөд мэргэжлийн үйл ажиллагааны тодорхойлолт, үнэлэх шалгуур байхгүй байна. Хичээл нөхөлтийг багш бодитой гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй, тус орлогоос багш нарт нэмэгдлийг тооцож олгож байна. "Оюутан эмнэлэг"-ийн үйл ажиллагааны дүрэм дотоод журам 3.6 заалтад заасан ажилчдад цалин олгох хувийг ул үндэслэлтэй тогтоогоогүй байгаа нь эмнэлгийн үйл ажиллагааны үр ашигт сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Эрсдэл

1. Багшын үнэлгээ алдаатай үнэлэгдэх

Зөвлөмж

Багш нарын сургалтын цагийн нормыг сургуулийн ойрын жилүүдийн багш нарын орон тоог урьдчилан тооцож АШУИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмын 4.5, 4.6 заалтуудыг баримтлан ажиллах. Багш нарын хичээлийн жилийн 1600 оноог дүгнэхдээ багшийн өөрийн үнэлгээг тэнхимийн эрхлэгч хянасны дараа сургалтын албаны дарга хянаж тайлант хугацааны илүү дутуу оноог гаргаж баталгаажуулж норм биелүүлээгүй багш нарыг АШУИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмын 2.9-д заасны дагуу цалингаас оногдох хувийг суутгах эсвэл амралтын хоногийг хорогдуулж ажиллах, дутуу оноог ямар үнэлгээгээр хорогдуулахыг журамд тодорхой болгох, багш нарын хичээл нөхөлтийн гүйцэтгэлийг бодитоор хянах

Хариуцах ажилтан

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн Захирал Ц.Цабшир нягтлан бодогч Э.Аззаяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 21-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.3 Удирдлагын дээд болон дотоод хяналт

Илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн зэрэгцүүлсэн хүүрнэсэн тайлбарласан толилуулаг хийдэггүйгээс Санхүүгийн ажилчид өөрчлөгдөх, чөлөөлөгдөх үед зарим ажил гүйлгээг буруу ойлгож ажил гүйлгээний үлдэгдлийг буруу илэрхийлэх ,тайлан гаргах хугацаанд нөлөөлөх зэрэг эрсдэл гарахаар байна Зарцуулсан мөнгөний үр дүнг баталсан баримт бүрдүүлээгүй, дотоод хяналт сул байна

Энэ нь Энэ нь иж бүрэн байх, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОС-1-53, “Тайлант үеийн санхүүгийн тайланг ойлгомжтой болгохын тулд зэрэгцүүлэг дэх мэдээлэлд хүүрнэсэн ба тайлбарласан мэдээллийг багтаах хэрэгтэй” стандарт заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

1. Мэдээллийг шуурхай авах боломж багасна, дотоод хяналтын ажил орхигдоно.

Зөвлөмж

Жил, хагас жилээр гаргаж байгаа санхүүгийн тайланд тайлбар мэдээллийг гаргаж хэвших, Гүйцэтгэх ажлуудыг урьдчилан төсөвлөж, гарах зардлыг тодорхой болгох, холбогдох баримтуудыг бүрдүүлснийг дараа бүртгэлд тусгаж байх.

Хариуцах ажилтан

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн Захирал Ц.Цабшир нягтлан бодогч Э.Аззаяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 21-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.4 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Илрүүлэлт

Тайлант онд худалдан авсан үндсэн хөрөнгийг хөрөнгөнд тусгаж ашиглаж байгаа хэдий ч ТБОНӨХБАҮХАТ -тай нийцүүлэн баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй, төсвийн хуваарьт нийцүүлэн худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь иж бүрэн байх, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 7.4.-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ.”заасан заалтын зөрчсөн байна.

Эрсдэл

1. Хөрөнгийн хөдөлгөөнийг зохицуулах арга аргачлал, хууль журмын биелэлт, бодит бүртгэлд тусгалд алдаатай илэрхийлэх эрсдэлтэй

Зөвлөмж

Төсөвт суусан эдийн засгийн ангиллын дагуу худалдан авалт хийх, хөрөнгийн хөдөлгөөнийг НББ бодлогын баримт бичигт заасны дагуу ангилан бүртгэж, элэгдлийг тооцож байх

Хариуцах ажилтан

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн Захирал Ц.Цабшир нягтлан бодогч Э.Аззаяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 21-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.5 Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Бараа материалыг орлогод авах, анхан шатны бүртгэл хөтлөхөөс эхлэн дансны ангиллыг зөв бүртгээгүйгээс 8526,0 мянган төгрөгийн бараа материалын ангилал хольж бүртгэсэн байна. Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан НХМаягт ТМ-5-аар нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлэх, зардлын баримтуудын хугацааг хянаж баримтад тусгах, холбогдох баримтын бүрдлийг хангах ажил хангалтгүй байна. Энэ нь Энэ нь иж бүрэн байх, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан НХМаягт ТМ-5-аар нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

1. Хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэх

Зөвлөмж

Бараа материалын ангиллыг зөв бүртгэх, худалдан авалт бүрд Е баримт авч баримтад хавсаргах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн Захирал Ц.Цабшир нягтлан бодогч Э.Аззаяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 21-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.6 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт

Мөнгөн хөрөнгийн зориулалтын бус, үр ашиггүй зарцуулах эрсдэлийг хааж бэлэн мөнгө тавьж олгох, зарцуулах, 4408,0 мянган төгрөгийн анхан шатны баримтыг бүртгэж хүлээн авах ажлуудыг харилцан хяналттай байхаар зохион байгуулаагүй байна. Өглөг, авлагын дансны хуримтлагдсан үлдэгдлийг Холбогдох яам, шийдвэр гаргагч нараар шийдвэрлүүлэх талаар хөөцөлдсөн боловч үр дүн гараагүй байна. Энэ нь Энэ нь иж бүрэн байх, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна 19.1.3.-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах”, 19.1.2.-т “батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” заалтыг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

1. Бэлэн мөнгөөр гүйлгээ хийх нь хөрөнгө алдагдах эрсдэлтэй
2. Он дамжсан өр авлага барагдахгүй байх эрсдэлтэй

Зөвлөмж

Бэлэн мөнгөөр худалдан авалт хийхгүй байх, тогтмол зардлын он дамжсан өр авлагыг шийдвэрлэх.

Хариуцах ажилтан

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн Захирал Ц.Цабшир нягтлан бодогч Э.Аззаяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 21-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.7 Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Амралтын газрын батлагдсан төсөв 28.0 сая боловч гүйцэтгэл 16.2 сая төгрөг, Орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн дагуу түрээсийн орлогоос төсөвт төвлөрүүлэх дүнг төвлөрүүлээгүй байна. Энэ нь Энэ нь иж бүрэн байх, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн дагуу “Түрээсийн орлогоос төсөвт төвлөрүүлэх Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна” заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

1. Төлөвлөгөө биелүүлээгүйгээс алдагдал үүсэх эрсдэлтэй

Зөвлөмж

Амралтын үйл ажиллагааны хяналт хариуцлага, менежмент сайжруулах шаардлагатай төлөвлөгөө тасарсанд хариуцлага тооцдог байх, өмчийн түрээсийн орлогын дүнгээс ИТХ-ийн шийдвэрт нийцүүлэн орлого төвлөрүүлэх

Хариуцах ажилтан

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн Захирал Ц.Цабшир нягтлан бодогч Э.Аззаяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 21-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.8 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

Илрүүлэлт

Спортын уралдаан тэмцээн, ахмадуудад олгосон нэг удаагийн тэтгэмжээс илүү татвар суутгаж иргэдийн гар дээр олгох 16,4 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Энэ нь Энэ нь иж бүрэн байх, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-ийн 22.1.2 болон 23.2.2 “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-ийн 16.1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

1. Иргэдийн гар дээр очих мөнгөн хөрөнгө буурах

Зөвлөмж

“Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу нэг удаагийн тэтгэмжээс татвар суутгахгүй байх.

Хариуцах ажилтан

Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн Захирал Ц.Цабшир нягтлан бодогч Э.Аззаяа

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 21-ний өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 10 дугаар сарын 25- ны дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ЛҮНДЭГМАА

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.БАЙГАЛ

Огноо:

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2120033514.21	2471841436.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1063704447.73	1176918427.53
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	921928312.91	1016827253.51
3121	Төгрөг	921928312.91	1016827253.51
31213	Арилжааны банк дахь харилцах	921928312.91	1016827253.51
31500	Хадгаламж	141776134.82	160091174.02
33	АВЛАГА	912108442.00	1181040370.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	4365644.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	472942358.00	488398650.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	439166084.00	687076076.00
335	Бусад авлага	0.00	1200000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		1200000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	144220624.48	113882638.56
351	Түүхий эд материал	4314609.78	4378261.83
35130	Эм боох материал	4314609.78	4378261.83
354	Хангамжийн материал	139906014.70	109504376.73
35410	Бичиг хэргийн материал	8235859.50	6741983.09
35420	Аж ахуйн материал	12234388.54	3365605.68
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	211100.00
35440	Түлш, шагах тослох материал	1518450.00	167361.00
35450	Барилгын засварын материал	11271951.41	2572340.19
35460	Хүнсний материал	48000.00	52750.00
35470	Бусад хангамжийн материал	106597365.25	96393236.77
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2459721448.10	2776828960.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2459721448.10	2776828960.05
392	Биет хөрөнгө	2451724781.37	2331573626.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	4474081710.46	1937943378.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	2477879642.96	53974531.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86928600.00	101928600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	42891695.41	55256020.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	250455654.15	277271792.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	161335948.24	194331051.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	538516211.90	567403772.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	334140492.45	375124197.89
39217	Ном	117990383.92	125711883.92
393	Биет бус хөрөнгө	7996666.73	445255333.47
39301	Програм хангамж	14200000.00	14200000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	6203333.27	8256666.53
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	439312000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4579754962.31	5248670396.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	217119254.00	324914868.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	217119254.00	324914868.00
413	Өглөг	0.00	156826711.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	156826711.00
414	Урьдчилж орсон орлого	217119254.00	168088157.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	159379754.00	168088157.00

АШУИС-ын салбар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41440	Бусад урьдчилж орсон орлого	57739500.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4362635708.31</u>	<u>4923755528.14</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4362635708.31	4923755528.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1058883757.56	1492195757.56
512	Хуримтлагдсан үр дүн	-139549559.25	99144499.38
51210	Өмнөх үеийн үр дүн	-139549559.25	-139549559.25
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	238694058.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3443301510.00	3332415271.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4579754962.31</u>	<u>5248670396.14</u>

4.2 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2489958425.46	2013483614.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2221645557.46	1745420782.61
120	Нийтлэг татварын бус орлого	2221645557.46	1735420782.61
120002	Хүүгийн орлого	62471863.79	73179802.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2081507446.59	1605125247.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1910894275.00	1427925325.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170613171.59	177199922.49
120005	Түрээсийн орлого	2059000.00	4532000.00
120009	Бусад орлого	75607247.08	52583733.00
122	Тусламжийн орлого	0.00	10000000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	10000000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	268312868.00	268062832.00
1330	Төсвийн захирагчдаас	268312868.00	268062832.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	268312868.00	268062832.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1842994832.91	1774789555.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1842994832.91	1774789555.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1825215736.91	1761595503.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	977829855.55	955262715.29
210101	Үндсэн цалин	977359855.55	768395052.31
210102	Нэмэгдэл	470000.00	137944417.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	41261296.53
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	7661949.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87700801.07	113625454.38
210201	Тэтгэврийн даатгал	87700801.07	111436654.38
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	2188800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268496699.00	261562488.00
210301	Гэрэл, цахилгаан	20662756.00	14686277.00
210302	Түлш, халаалт	209579667.00	209923791.00
210303	Цэвэр, бохир ус	38254276.00	36952420.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55436180.17	70797127.01
210401	Бичиг хэрэг	16895714.45	27760788.84
210402	Тээвэр, шатахуун	9088572.27	7490756.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10422856.49	8828782.89
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1956706.53
210408	Бараа материал акталсны зардал	19029036.96	24760092.75
2105	Нормативт зардал	19397615.11	15800206.17
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4081310.09	3385749.96
210502	Хоол, хүнс	5783625.00	2963295.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9532680.02	9451161.21
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	158442714.81	72645984.59
210601	Багаж, техник, хэрэгсэл	625488.94	1950412.74
210604	Урсгал засвар	157817225.87	70695571.85
2107	Томилолт, зочны зардал	14744845.00	33130734.00
210701	Гадаад албан томилолт	7293245.00	26964744.00
210702	Дотоод албан томилолт	7451600.00	6165990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118526.40	1615331.00

АШУИС-ын салбар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118526.40	1615331.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	243048499.80	237155463.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10671650.00	3229206.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58901270.98	64494309.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173475578.82	169431948.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17779096.00	13194052.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17779096.00	13194052.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17779096.00	13194052.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>646963592.55</u>	<u>238694058.63</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>646963592.55</u>	<u>238694058.63</u>

4.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2136559754.46</u>	<u>1709265594.61</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1956559754.46	1676646016.61
120	Нийтлэг татварын бус орлого	1956559754.46	1666646016.61
120002	Хүүгийн орлого	62471863.79	40492204.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1817771950.59	1528841155.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1592268380.00	1353590776.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	225503570.59	175250379.49
120005	Түрээсийн орлого	450000.00	4212000.00
120009	Бусад орлого	75865940.08	93100656.64
122	Тусламжийн орлого	0.00	10000000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	10000000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	180000000.00	32619578.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	30000000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	30000000.00
1330	Төсвийн захирагчдаас	180000000.00	0.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	180000000.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	2619578.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	2619578.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1889615467.33</u>	<u>1596051614.81</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1889615467.33	1596051614.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1878526208.33	1582714162.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	970173295.62	961353097.27
210101	Үндсэн цалин	969308737.62	823203742.32
210102	Нэмэгдэл	864558.00	110067153.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	23336897.03
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	4745304.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104883036.70	113061447.40
210201	Тэтгэврийн даатгал	104883036.70	113061447.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	364550483.00	111388130.00
210301	Гэрэл, цахилгаан	20662866.00	21338630.00
210302	Түлш, халаалт	309139065.00	90000000.00
210303	Цэвэр, бохир ус	34748552.00	49500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37685745.69	43406579.89
210401	Бичиг хэрэг	10596153.20	18361080.00
210402	Тээвэр, шатахуун	8842500.00	6139667.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10422856.49	8828782.89
210404	Ном, хэвлэл	7824236.00	7733100.00

АШУИС-ын салбар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	2343950.00
2105	Нормативт зардал	18920053.60	9021980.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5894510.00	1033516.00
210502	Хоол, хүнс	4891351.60	2820045.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8134192.00	5168419.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	289271900.52	237880058.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	141557069.52	21295000.00
210602	Тавилга	0.00	63876303.00
210604	Урсгал засвар	147714831.00	152708755.00
2107	Томилолт, зочны зардал	15044845.00	33130734.00
210701	Гадаад албан томилолт	7293245.00	26852744.00
210702	Дотоод албан томилолт	7751600.00	6277990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11133560.40	1615331.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11133560.40	1615331.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66863287.80	71856805.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10376159.80	10185234.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56487128.00	61671571.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11089259.00	13337452.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11089259.00	13337452.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11089259.00	13337452.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	246944287.13	113213979.80
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	7968575.00	0.00
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7968575.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	7968575.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	254912862.13	113213979.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	808791585.60	1063704447.73
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1063704447.73	1176918427.53

4.4 АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн	1,058,883,757.56	3,443,301,510.00	- 139,549,559.25	4,362,635,708.31
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,058,883,757.56	3,443,301,510.00	- 139,549,559.25	4,362,635,708.31
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,117,767,515.12	6,886,603,020.00	- 279,099,118.50	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	433,312,000.00	- 110,886,238.80		322,425,761.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,492,195,757.56	3,332,415,271.20	- 139,549,559.25	4,685,061,469.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			238,694,058.63	238,694,058.63
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,492,195,757.56	3,332,415,271.20	99,144,499.38	4,923,755,528.14

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2247113700.00	1596051614.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2247113700.00	1596051614.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2203185000.00	1582714162.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1184001300.00	961353097.27
210101	Үндсэн цалин	984001300.00	823203742.32
210102	Нэмэгдэл	130000000.00	110067153.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55000000.00	23336897.03
210105	Гэрээт ажлын хөлс	15000000.00	4745304.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130240200.00	113061447.40
210201	Тэтгэврийн даатгал	130240200.00	113061447.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	288119600.00	111388130.00
210301	Гэрэл, цахилгаан	32142000.00	21338630.00
210302	Түлш, халаалт	210516800.00	90000000.00
210303	Цэвэр, бохир ус	45460800.00	49500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	107335300.00	43406579.89
210401	Бичиг хэрэг	20940000.00	18361080.00
210402	Тээвэр, шатахуун	14850300.00	6139667.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19145000.00	8828782.89
210404	Ном, хэвлэл	32400000.00	7733100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20000000.00	2343950.00
2105	Нормативт зардал	68275300.00	9021980.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6700000.00	1033516.00
210502	Хоол, хүнс	32000000.00	2820045.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29575300.00	5168419.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	283824500.00	237880058.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26480000.00	21295000.00
210602	Тавилга	58732000.00	63876303.00
210604	Урсгал засвар	198612500.00	152708755.00
2107	Томилолт, зочны зардал	39065000.00	33130734.00
210701	Гадаад албан томилолт	26460000.00	26852744.00
210702	Дотоод албан томилолт	12605000.00	6277990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1615331.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1615331.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102323800.00	71856805.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22430500.00	10185234.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79893300.00	61671571.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43928700.00	13337452.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43928700.00	13337452.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43928700.00	13337452.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2184473600.00	1571460733.49
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	288119600.00	30000000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	288119600.00	30000000.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	2619578.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	2619578.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1896354000.00	1528841155.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1783854000.00	1353590776.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112500000.00	175250379.49
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.00	10000000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	10000000.00

